БАТЛАВ
ДОРНОД АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА М.БАДАМСҮРЭН

ОРОН НУТАГТ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ МАЛЫН ҮҮЛДЭР ОМГИЙГ НЭМЭГДҮҮЛЭН ЦӨМ СҮРЭГ БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

1. Байршил:
   1.1.Баяндун сумын Буриад омгийн хуц 1200 толгой
   1.2.Баян-Уул сумын Буриад омгийн хуц 600 толгой, Казакын цагаан толгойт үхэр 2900 толгой,
   1.3.Дашбалбар сумын Буриад омгийн хуц 1600 толгой, хээлтэгч 5500 толгой
   1.4.Сэргэлэн сумын Үзэмчин үүлдрийн хуц 1200 толгой, хээлтэгч 5565 толгой
   1.5.Хөлөнбуйр сумын Барга үүлдрийн хуц 1200 толгой, хээлтэгч 5500 толгой
   1.6.Цагаан-Овоо сумын Буриад омгийн хуц 1300 толгой
   1.7.Цагаан-Овоо сумын Цагаан-Овоогийн хар ухна 900 толгой, хээлтэгч 5500 толгой
   1.8.Халхгол сумын Дорнод Монголын улаан үүлдрийн үхэр 3000 толгой
   аймгийн хэмжээнд 7 сумын 35.965 толгой малыг хамруулна.

2.Үржлийн малд үзлэг ангилалт хийх, баталгаажуулах цөм сүрэг бүрдүүлэхэд тавигдах шаардлага: Үржлийн малд үзлэг ангилалт хийх, баталгаажуулах цөм сүрэг бүрдүүлэхэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 25 өдрийн А/71 дүгээр тушаалаар батлагдсан Мал ангилах зааврын ерөнхий зарчмын дагуу "Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж" хийж гүйцэтгэнэ.

3.Цөм сүргийн үхрийн босго үзүүлэлтүүд:

3.1.Махны чиглэлийн үржлийн үхэрт ангилалтыг жил бүрийн 10 дугаар сарын сүүлийн хагаст галбир, бие цогцос, махлаг шинжийн үндсэн үзүүлэлтүүдийг харгалзан аль сүрэгт хамрагдахыг тодорхойлно. Ангилалтад хамрагдаж байгаагүй бух, үнээ, нэмрийн гунж, чиглэлтэй бойжуулсан өсвөр бухыг тус тус ангилалтад хамруулан цөм сүрэг, үржлийн сүрэг, хэрэгцээний сүрэг гэж ангилна.

| д/д | Нас, хүйс | Амьждын жин, кг, /намар/ | Биеийн үндсэн хэмжээ | | | Үндсэн зүй, онцлог |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Биеийн ташуу урт | Цээжний бүслүүр | Сэрвээний өндөр | |
| **Дорнод Монголын улаан үүлдрийн үхэр** | | | | | | |
| 1 | Бух | 400 | 142 | 177 | 122 | Дорнод Монголын улаан үүлдрийн үхэр нь махлаг хэв шинжийг сайн илэрхийлсэн өргөн бөөрөнхий биетэй, булчин ясны хөгжил сайтай. |
| 2 | Үнээ | 360 | 134 | 172 | 118 | |
| 3 | Өсвөр, бух | 380 | 130 | 170 | 115 | |
| 4 | Нэмрийн гунж | 270 | 127 | 165 | 113 | |
| **Казахын цагаан толгойт үүлдрийн үхэр** | | | | | | |
| 1 | Бух | 420 | 155 | 183 | 125 | Казахын цагаан толгойт үүлдрийн хэв шинжийг бүрэн хадгалсан, гуя хонгоны махны дүүргэлт сайн, булчин махны хөгжил жигд, цээж бөгс тэнцүү, нядлагын гарц, жингээр махны төрөлжсөн үүлдэртэй ойролцоо Гүн улаан халзан зүстэй, нүдний цагираг улаан хүрээтэй, бэлхүүс, сэрвээ, сүүлний үзүүр цагаан |
| 2 | Үнээ | 380 | 150 | 178 | 117 | |
| 3 | Өсвөр, бух | 320 | 130 | 170 | 115 | |
| 4 | Нэмрийн гунж | 280 | 130 | 165 | 112 | |

**4."Мах-өөх-бүдүүн ноос"-ны чиглэлийн өөхөн сүүлт хонины цөм сүргийн босго үзүүлэлтүүд:**

4.1.Хонины ашиг шимийн болон галбир, бие ялдар, үржлийн чанарт үнэлгээ өгч сүргийн ангилалд тодорхойлох бөгөөд үржлийн болон хэрэгцээний сүрэгт орох хонинд ангийн ангилалт хийж, им тавьж, бүртгэлд хамруулна. Харин цөм сүргийн шаардлага хангасан хонинд хувьсын ангилалт хийж, хонь нэг бүрийн босго үзүүлэлтүүдийг хувьсын бүртгэлд маягтын дагуу хөтлөнө.

4.2.Ашиг шимийн энэ чиглэлд Үзэмчин, Барга үүлдэр, Буриад омгийн хонийг үржүүлж байгаа иргэд, аж ахуйн нэгжийн хонинд ангилалтыг жил бүрийн 10 дугаар сарын эхний хагаст багтаан, мах-өөхний шинж тодорсон байдал болон галбир, биеийн ерөнхий өсөлт, хөгжлийн үзүүлэлтүүдийг голлон шинжиж ангилна. Жил бүр цөм сүрэгт хамрагдсан хонинд хяналтын хяргалт, 5 дугаар сард хаврын амьдын жинг тодорхойлж үржлийн гэрчилгээнд баяжилт хийнэ.

| д/д | Нас, хүйсний ялгаа | Амьдын жин, кг | | Ноосны гарц кг | Товч тайлбар |
|---|---|---|---|---|---|
| | | Хаврын | Намрын | | |
| **Үзэмчин үүлдрийн хонь** | | | | | |
| 1 | Нас гүйцсэн хуц | 52 | 65 | 1,2 | Үзэмчин үүлдрийн хонины товч тайлбар дахь нийтлэг босго үзүүлэлтүүдтэй ижил байхын зэрэгцээ Үзэмчин үүлдрийн хонь нь шар халзан, шар, улаан толгойтой цагаан зүстэй, мах-өөхний хэв шинж илүүтэй тодорсон, богино тачир ямаан үс бүхий бүдүүн ноостой, сүүл нь дугуй буюу өргөн том, эрүүл чийрэг, галбирын согоггүй хонь байна. |
| 2 | Төлгөн хуц | 33 | 50 | 1,0 | |
| 3 | Эм хонь | 40 | 55 | 1,1 | |
| 4 | Охин төлөг | 30 | 45 | 0,8 | |
| **Барга үүлдрийн хонь** | | | | | |
| 1 | Нас гүйцсэн хуц | 50 | 63 | 1,2 | Барга үүлдрийн хонины товч тайлбар дахь нийтлэг босго үзүүлэлтүүдтэй ижил байхын зэрэгцээ Барга үүлдрийн хонь нь махөөхний хэв шинж сайн тодорсон, улаан толгойтой, шар халзан зүстэй, сүүл ууц нуруундаа харьцангуй их хэмжээний өөх хуримтлуулсан, бага зэрэг өргөгдсөн богино зузаан отгогүй мухар өөхөн сүүлтэй, галбирын согоггүй, эрүүл чийрэг хонь байна. |
| 2 | Төлгөн хуц | 32 | 46 | 1,0 | |
| 3 | Эм хонь | 39 | 52 | 1,1 | |
| 4 | Охин төлөг | 30 | 42 | 0,9 | |
| **Буриад омгийн хонь** | | | | | |
| 1 | Нас гүйцсэн хуц | 60 | 70 | 1,8 | Буриад үүлдрийн хонины товч тайлбар дахь нийтлэг босго үзүүлэлтүүдтэй ижил байхын зэрэгцээ Буриад омгийн хонь нь цээж өргөн, гүн, ууц ялимгүй өргөгдсөн, харьцангуй богино зузаан өөхөн сүүлтэй, улаан, шар, бор толгойтой, их бие нь хундан цагаан зүстэй, туг хэлбэрийн бүдүүн ноостой, эрүүл чийрэг хонь байна. |
| 2 | Төлгөн хуц | 35 | 52 | 1,2 | |
| 3 | Эм хонь | 40 | 55 | 1,3 | |
| 4 | Охин төлөг | 32 | 48 | 1,1 | |

**5.Цөм сүргийн ямааны ашиг шимийн гарц, чанарын босго үзүүлэлт:**

5.1.Ашиг шимийн чиглэлийн дагуу ямааг зүс, галбир, шүд, биеийн хэсгүүдийн хөгжил, харьцаа тухайлбал, хөл мөч, үржлийн эрхтэн, дэлэн хөхний хэлбэр, хэмжээ, эрүүл мэнд, тэсвэрт чанарын гадаад илэрхийлэл, амьдын жин, ноолуур агууламж, ноолуурын гарц, урт, нарийн бүдүүн (голч), жигдлэгийн үзүүлэлтийг харгалзан сүргийн ангиллыг тодорхойлно.

5.2.Манай оронд үржүүлж байгаа ямаан сүрэгт ашиг шимийн дараах чиглэлийн дагуу ангилалтыг жил бүр 3-4 дүгээр сард багтаан явуулж цөм сүрэгт тэнцсэн нас гүйцсэн ухна, борлон ухна, охин борлонгоос 3-5 гр ноолуурын дээж авч лабораторид голчийг, хавар ангилалтын дараа цөм сүрэгт хамрагдсан ямаа бүрийн ноолуурын гарцыг самналтаар, 10 дугаар сард амьдын жинг тус тус тодорхойлж, үржлийн гэрчилгээнд баяжилт хийнэ.

| № | Нас хүйсний ялгаа | Амьдын жин, кг | | Ноолуур | | | | | Үндсэн зүс |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хаврын | Намрын | Агууламж % | Гарц, кг | Урт, мм | Голч, мкм | Өнгө | |
| 1 | Нас гүйцсэн ухна | 44.1 | 56.2 | 84.9 | 310 | 4.48 | 16.7 | цайвар | Хар |
| 2 | Борлон ухна | 16.5 | 32.3 | 85.4 | 150 | 4.85 | 14.2 | цайвар | Хар |
| 3 | Эм ямаа | 35.2 | 47.5 | 89.9 | 403 | 5.08 | 16.1 | цайвар | Хар |
| 4 | Охин борлон | 19.0 | 27.7 | 89.9 | 315 | 4.78 | 15.6 | цайвар | Хар |

## 6.Гүйцэтгэх ажлын үзүүлэлт:

6.1. Багц-1 хүснэгт

| д/д | Багц | Сум | Үүлдэр, омог | Малын тоо, толгой | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хээлтүүлэгч | | | Хээлтэгч | | | Нийт |
| | | | | Бүгд | Бух | Өсвөр бух | Бүгд | Үнээ | Нэмрийн гунж | |
| 1 | Багц-1 | Баян-Уул | Казакын цагаан толгойт үүлдрийн үхэр | 437 | 305 | 132 | 2463 | 1438 | 1025 | 2900 |
| | | **Дүн** | | **437** | **305** | **132** | **2463** | **1438** | **1025** | **2900** |
| 2 | | Халхгол | Дорнод Монголын улаан үүлдэр | 323 | 227 | 96 | 2677 | 1607 | 1070 | 3000 |
| | | Дүн | | **323** | **227** | **96** | **2677** | **1607** | **1070** | **3000** |
| **Дүн** | | | | **760** | **532** | **228** | **5140** | **3045** | **2095** | **5900** |

6.2. Багц-2 хүснэгт

| д/д | Багц | Сум | Үүлдэр, омог | Малын тоо, толгой | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хээлтүүлэгч | | | Хээлтэгч | | | Нийт |
| | | | | Бүгд | Нас гүйцсэн хуц | Төлгөн хуц | **Бүгд** | Эм хонь | Охин төлөг | |
| 1 | Багц-2 | Баяндун | Буриад омгийн хонь | 1200 | 823 | 377 | **0** | 0 | 0 | 1200 |
| 2 | | Дашбалбар | Буриад омгийн хонь | 1600 | 1105 | 495 | **5500** | 3500 | 2000 | 7100 |
| **3** | | **Дүн** | | 2800 | **1928** | **872** | **5500** | **3500** | **2000** | **8300** |
| 4 | | Баян-Уул | Буриад омгийн хонь | 600 | 420 | 180 | **0** | 0 | 0 | 600 |
| 5 | | Сэргэлэн | Үзэмчин үүлдрийн хонь | 1200 | 840 | 360 | **5565** | 3565 | 2000 | 6765 |
| **6** | | **Дүн** | | 1800 | **1260** | **540** | **5565** | **3565** | **2000** | **7365** |
| 7 | | Цагаан-Овоо | Буриад омгийн хонь | 1300 | 948 | 352 | **0** | 0 | 0 | 1300 |
| | | **Дүн** | | 1300 | **948** | **352** | **0** | **0** | **0** | **1300** |
| 8 | | Хөлөнбуйр | Барга үүлдрийн хонь | 1200 | 839 | 361 | **5500** | 3500 | 2000 | 6700 |
| **Дүн** | | | | 1200 | **839** | **361** | **5500** | **3500** | **2000** | **6700** |
| **Нийт дүн** | | | | 7100 | **5088** | **2178** | **16565** | **10565** | **6000** | **23665** |

6.2.1. Багц-3 хүснэгт

| д/д | Багц | Сум | Үүлдэр, омог | Малын тоо, толгой | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хээлтүүлэгч | | | Хээлтэгч | | | Нийт |
| | | | | Бүгд | Нас гүйцсэн ухна | Борлон ухна | Бүгд | Эм ямаа | Охин борлон | |
| 1 | Багц-2 | Цагаан-Овоо | Цагаан-Овоогийн хар омгийн ямаа | 900 | 630 | 270 | 5500 | 3500 | 2000 | 6400 |
| | | **Дүн** | | **900** | **630** | **270** | **5500** | **3500** | **2000** | **6400** |

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А/68 дугаар тушаалын Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний төрөл, жишиг үнийг баримтлан мөрдөнө.

6.2.2. Багц-4

**2. Байршил:**

2.1. Халхгол суманд Дорнод Монголын улаан үүлдрийн 1 настай 5 толгой бухыг худалдан авах

3. **Бод малын хээлтүүлэгчийг худалдан авах ажилд тавигдах шаардлага:**

3.1. Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 6 дугаар зүйлийн 6.4, 11 дүгээр зүйлийн 11.6.2 заалтуудын дагуу хийж гүйцэтгэнэ.

3.2. Мал шинжээч мэргэжилтэн , мэргэжлийн байгууллагаар малдаа жил бүр үзлэг ангилалт хийлгэж, үржлийн анхан шатны бүртгэлийг бүрэн хөтөлсөн байх

3.3. Мэргэжлийн байгууллагаар малынхаа удам гарваль, ашиг шимийн гарц чанарыг тогтоолгож баталгаажуулсан гэрчилгээтэй байх

3.4. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд жил бүр малаа бүрэн хамруулж, эрүүл болохыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгосон байх

3.5. Цөм сүргийн хээлтүүлэгч нь ашиг шимийн дундаж үзүүлэлт нь тухайн үүлдэр омгийн малын нэг ба түүнээс дээш ангийн шаардлагыг хангасан байх
3.6. Малыг үл давтагдах хувийн дугаараар ялган тэмдэглэж, бүртгэнэ.
3.7. Бод малын хээлтүүлэгч нийлүүлж буй иргэн, аж ахуйн нэгж нь тээврийн зардлыг хариуцах

## 4. Дорнод Монголын улаан үүлдрийн үхрийн босго үзүүлэлтүүд:

3.1. Хүснэгт стандарт үзүүлэлт:

| д/д | Нас, хүйс | Амьдын жин, кг, /намар/ | Биеийн үндсэн хэмжээ | | | Үндсэн зүй, онцлог |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Биеийн ташуу урт | Цээжний бүслүүр | Сэрвээний өндөр | |
| **Дорнод Монголын улаан үүлдрийн үхэр** | | | | | | |
| 1 | Өсвөр, бух | 380 | 130 | 170 | 115 | Дорнод Монголын улаан үүлдрийн үхэр нь махлаг хэв шинжийг сайн илэрхийлсэн өргөн бөөрөнхий биетэй, булчин ясны хөгжил сайтай. |

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН,
ХЭЛТСИЙН ДАРГА М.НЯМСҮРЭН

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.БАЯРСАЙХАН

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН С.СОЛОНГО

АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.МӨНХБАЯР

БОЛОВСРУУЛСАН:
АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН МАЛ
ҮРЖЛИЙН АЛБАНЫ ДАРГА Д.НАРАНХҮҮ